



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/342

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Тарваган тахлын голомтот Алтай, Булган, Мөст, Цэцэг, Үенч сумдын ард иргэдэд урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийх замаар хүний өвчлөл гарах эрсдлийг бууруулах зардалд 2.000.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 000 000 төгрөг /Хоёр сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас хамгаалах зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ